

### **3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ерөнхий менежерийн ерөнхийлөн захирагчтай тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 38.8 , тухайн жилд ач холбогдолтой гэж сонгож авсан бүтээгдэхүүний биелэлтийг 27.5 , төрийн албан хаагчийн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, дээшлүүлэх талаар хүлээсэн үүргийн биелэлт бүрэн дүүрэн 30 оноотойгоор тухайн жилийн бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг 96.3 оноогоор буюу “А” буюу маш сайн үнэлгээтэйгээр биелүүлсэн байна.

**Тухайлбал:** Тайлангийн хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газар нь Засаг даргын өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн төлөө бодлого үйл ажиллагаагаа бүрэн зориулан ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолыг үндэслэн сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн зохион байгуулсан байна.

Төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй, шударга шуурхай болгож үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Сар бүрийн 25-ны өдөр”-ийг иргэдээ сонсох өдөр болгон нээлттэй утас байнга ажиллуулж, энэ үеэр иргэдэд аймагт үйл ажиллагаа явуулж төрийн байгууллагын талаар мэдээлэл өгөх, иргэдийн санал хүсэлтийг сонсох, хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгч, гарын авлага материал тараах зэргээр иргэдтэй хамтран ажиллаж байна.

Засаг даргын дэргэд төрийн зөв бодлого явуулахад дэмжлэг үзүүлэх, төрийн үйл хэрэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төрийн захиргааны байгууллагын ахмад ажилтан, эрдэмтэн судлаачид, ахмад, дунд, залуу үеийнхэн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн бодлогын зөвлөлийг аймгийн Засаг даргын 2009 оны 68 дугаар захирамжаар 28 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан дотор нь нийгмийн болон эдийн засгийн гэсэн 2 салбар бүтэцтэйгээр ажиллуулж байна.

Оны эхнээс бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж гэрээний заалтыг нэг бүрчлэн ханган биелүүлэх, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллаа.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хангуулан ажиллахын зэрэгцээ аймаг орон нутгийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг зохион байгуулах, шийдвэрлэх арга замыг оновчтой төлөвлөх, бодлогын зөвлөгөө, дэмжлэгээр байнга тасралтгүй хангаж байна.

2009 онд манай аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан ХХААХҮ яамны өдөр, гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, сум багийн удирдлагуудыг оролцуулсан өвөлжилтийн бэлтгэл хангах үзүүлэх сургууль, Алтанхөхий уулын өндөр хөхийн овоог тайх ёслол, олон улсын яармаг худалдаа зэргийг нэрлэж болно.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, ард иргэдээ оюунжуулах, эдийн засгийн хямралыг даван туулах талаар алсын хараатай бодлого боловсруулж, бодитой алхмуудыг хийлээ. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дутагдаж байгаа хөрөнгө, төсвийг босгох ажлын хэсгийг яамдад ажиллуулсан, оюунлаг багш, эмч, оюутан сурагч, гэр бүл шалгаруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмын хэрэгжилтийг тооцох журам, санхүү эдийн хүндрэл бэрхшээлийг даван туулах Ховд аймгийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг баримт бичиг боловсруулж хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулжээ.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай бэлтгэж хангалттай дүн үзүүлээ.

Төрийн албыг цомхон, чадварлаг байлгахад онцлон анхаарч, төрийн байгууллага, иргэнийг холбосон орон тооны бус бодлогын зөвлөл байгуулж иргэдийн санал гомдол, эрэлт хүсэлтийг анхааралтай судлан шийдвэрлэж, төр

захиргааны үйл ажиллагааг ард түмэнд сурталчлах чиглэлээр нилээд чухал асуудлыг дэвшүүлэн ажиллаж байна.

Иймд аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлого, явуулж байгаа үйл ажиллагааг дүүрэн хангалттай гэж үнэлж байна.

ЗАСАГ ДАРГА

Г. НЯМДАВАА